

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12/02 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн хөрөнгө оруулалт:

Төрөл Төсөл арга хэмжээний тоо Санхүүжих дүн

Шилжих 69 төсөл арга хэмжээ 28,845.6 сая ₮

Шинээр эхлэх 370 төсөл арга хэмжээ 47,157.8 сая ₮

НИЙТ 439 төсөл арга хэмжээ 76,003.4 сая ₮

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийн зорилго зорилтод нийцсэн байна.

Баян-Өндөр сумын төсвийн хөрөнгө оруулалтаар:



**1,772.4 сая ₮-н төсөвт өртөгтэй
13 төсөл арга хэмжээ**

Жаргалант сумын төсвийн хөрөнгө оруулалтаар:



**4,540.0 сая ₮-н төсөвт өртөгтэй
29 төсөл арга хэмжээ**

хэрэгжүүлэхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталжээ.

Шинээр эхлэх төсөл арга хэмжээний:



Барилга байгууламж-48 төсөл арга хэмжээ буюу 11.7%



Тоног төхөөрөмж- 52 төсөл арга хэмжээ буюу 12.7%



Их засвар- 32 төсөл арга хэмжээ буюу 7.8%



Зөвлөх үйлчилгээ- 4 төсөл арга хэмжээ буюу 1.0%



Төсөл хөтөлбөр - 274 төсөл арга хэмжээ буюу 67.0%

Дээрх төсөл арга хэмжээнээс хөрөнгөд бүртгэх боломжгүй урсгал зардалд төсвийн 24.4 хувийг зарцуулахаар төлөвлөж, 274 төсөл, хөтөлбөр нь төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй байна.

2020 оноос одоог хүртэл дуусаагүй 3 барилга байгууламж байна.



• Төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, олон нийтээс санал аваагүй, эдийн засгийн үр ашгийн тооцоо судалгаа, төсөвт нөлөөлөх дүгнэлт огт гаргаагүй байна.

• Төсөл арга хэмжээг батлахаас өмнө зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийж, магадлалын ерөнхий дүгнэлт гаргаагүй 8 төсөл арга хэмжээ байна.

• Өмнөх оны шилжих 8 төсөл арга хэмжээний төсөвт өртөгийг нэмэгдүүлж баталсан хэдий ч нэмэгдсэн төсөвт магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан эсэх нь тодорхойгүй байна.

Худалдан авах ажиллагаанд баримталсан журам



Нээлттэй тендер шалгаруулалт

Харьцуулалт

Шууд худалдан авалт

Бусад

Нийт

Төсөвт өртөг

	Нээлттэй тендер шалгаруулалт	Харьцуулалт	Шууд худалдан авалт	Бусад	Нийт	Төсөвт өртөг
Аймгийн Засаг Даргын Тамгын газар	89	65	20	14	188	38,151.1 сая ₮
Баян-Өндөр сумын Засаг Даргын Тамгын газар	4	35	40	4	83	3,653.9 сая ₮
Жаргалант сумын Засаг Даргын Тамгын газар	8	12	35	1	56	10,983.3 сая ₮
НИЙТ	101	112	95	19	327	52,788.3 сая ₮


Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу шалгаруулаагүй, холбогдох байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.



Нийт 481 төсөл арга хэмжээний 2023 оны санхүүжилт 82,316.6 сая төгрөг санхүүжүүлэхээс 57,098.4 сая төгрөг буюу 69.3%-ийг олгосон байна.

	Нийт төсөл арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн	Он дамжин хэрэгжих	ХАА зохион байгуулаагүй	Гүйцэтгэлийн %
Барилга байгууламж	91	67	4	6	73.6%
Их засвар	38	32			84.2%
Тоног төхөөрөмж	62	55	1	4	88.7%
Зөвлөх үйлчилгээ	15	9		5	60.0%
Төсөл хөтөлбөр	275	270		5	98.1%
НИЙТ	481	433	5	17	90.0%


Төлөвлөсөн хугацааг сунгасан гүйцэтгэгчтэй гэрээний хариуцлага тооцдоггүйгээс дуусаагүй төсөл арга хэмжээ байсаар байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнд **Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ** захиалагчийн тавих үе шатны явцын болон техникийн хяналтыг хэрэгжүүлжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс 8 төсөл, арга хэмжээ чанаргүй гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 270 төсөл, хөтөлбөрийн зардал нь хөрөнгийн бус зардлын шинж чанартай тул хөрөнгөд бүртгээгүй байна.



Бүрэн хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний 98 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

ДҮГНЭЛТ:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шаардлага хангаагүй төсөл, хөтөлбөрийг төлөвлөн, санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ:



57.3 сая ₮-н 7 төлбөрийн акт тогтоолоо.



Зөрчлийг давтан гаргахгүй байх 112 сая ₮-н 5 албан шаардлага хүргүүллээ.



Алдааг залруулах 21,096.1 сая ₮-н 10 зөвөмж хүргүүллээ.



Цахим хуудас:

open.audit.mn

facebook page:

Орхон аймаг дахь Төрийн Аудитын газар

Утас: 70353088, 70357955

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.